

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/54/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261205 Цахим хаяг: khosjargalts@audit.mn Аудитор: Д.Болор-Эрдэнэ Утас: 261205 Цахим хаяг: bolorderened@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн захирал: Д.Эхбаяр Утас: 99116948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
М.ДАВААБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/326

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд 277,541.6 мянган төгрөгийн авлага, 150,779.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Тайлант хугацаанд эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах тендерт ирүүлсэн оролцогчдын материалыг чанар ба үнэлгээний аргаар үнэлээгүй.
- Худалдан авах ажиллагааны Багц 2 -т шалгарсан Мисс ди ХХК-аас (гэрээний үнийн дүн 168,623.2 мянган төгрөг) тендерийн гүйцэтгэлийн баталгаа аваагүй, тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг тусгаагүй

зэрэг зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 28 дугаар зүйлийн 28.7.5, 43 дугаар зүйлийн 43.4, 43.4.2, 46 дугаар зүйлийн 46.1.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйлийн 20.2.3-д заасантай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсанаас эрх бүхий байгууллагын шийдвэрээр тайланд онд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд ашиглах 378,414.8 мянган төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан байна.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас чиглэл өгсний дагуу тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох ажил мэргэжлийн жагсаалтад иж бүрэн судалгаа хийж үнэлэлт, дүгнэлт ажлыг гүйцэтгэхэд 23,000.0 мянган төгрөг, Эрүүл ажлын байрыг эрхэмлэгч байгууллага, арга хэмжээ зохион байгуулахад 25,000.0 мянган төгрөг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр эрсдэл өндөр салбарт контент хийж түгээхэд 20,000.0 мянган төгрөг төлөвлөж, зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	594,069,992.40	639,862,849.29
33	АВЛАГА	375,869,732.70	331,887,890.84
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	16,541,072.59	14,301,722.90
33300	Татаас, санхүүжилтийн авлага	14,762,521.00	0.00
335	Бусад авлага	344,566,139.11	317,586,167.94
3351	Байгууллагаас авах авлага	339,457,635.11	312,477,663.94
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,108,504.00	5,108,504.00
35	БАРАА МАТЕРИАЛ	218,200,259.70	307,974,958.45
351	Түүхий эд материал	97,789,294.99	162,773,243.74
35130	Эм боох материал	97,789,294.99	162,773,243.74
354	Хангамжийн материал	120,410,964.71	145,201,714.71
35410	Бичиг хэргийн материал	14,422,935.00	43,334,385.00
35420	Аж ахуйн материал	11,400,018.00	7,279,318.00
35430	Сэлбэг хэрэгсэл	14,889,800.00	14,889,800.00
35440	Түлш, шатах тослох материал	-	-
35470	Бусад хангамжийн материал	79,698,211.71	79,698,211.71
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,737,436,971.34	2,421,337,365.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,737,436,971.34	2,421,337,365.84
392	Биет хөрөнгө	1,663,745,318.19	2,353,766,212.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,279,846,891.00	2,279,846,891.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(441,245,803.34)	(495,899,571.62)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	176,900,000.00	176,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(176,900,000.00)	(176,900,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,065,122,465.60	1,305,251,244.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,265,276,170.69)	(1,081,882,712.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	150,342,834.30	153,846,552.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	(130,753,153.68)	(137,243,871.99)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,888,355.00	366,861,085.11
39215	Хуримтлагдсан элэгдэл	(643,500.00)	(38,476,803.05)
39217	Ном	1,463,400.00	1,463,400.00
393	Биет бус хөрөнгө	73,691,653.15	67,571,153.19
39301	Программ хангамж	138,220,000.00	142,042,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(112,411,666.85)	(122,354,666.81)
39303	Бусад биет бус хөрөнгө	47,883,320.00	47,883,320.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,331,506,963.74	3,061,200,215.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	144,701,408.00	256,513,563.78
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	144,701,408.00	256,513,563.78
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,481,138.00	98,128,157.38
41361	Байгууллагад төлөх өглөг	75,124,770.00	36,405,876.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		656,515.00
414	Урьдчилж орсон орлого	67,095,500.00	121,323,015.40
41440	Бусад урьдчилж орсон орлого	67,095,500.00	121,323,015.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,186,805,555.74	2,804,686,651.35
51	Засгийн газрын хувь оролцоо	2,186,805,555.74	2,804,686,651.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	690,350,380.90	690,350,380.90
51101	Өмч:- төрийн	690,350,380.90	690,350,380.90
512	Хуримтлагдсан үр дүн	1,496,455,174.84	2,114,336,270.45
51210	Өмнөх үеийн үр дүн	1,785,294,733.69	1,766,742,809.44
51220	Тайлант үеийн үр дүн	(288,839,558.85)	347,593,461.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,331,506,963.74	3,061,200,215.13

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,094,993,651.00	3,883,181,844.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,137,038,830.00	1,801,970,784.86
120	Нийтлэг татварын бус орлого	1,137,038,830.00	1,801,970,784.86
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,137,038,830.00	1,223,507,453.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,086,373,901.00	1,223,507,453.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,968,129.00	420,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,696,800.00	578,043,331.86
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,957,954,821.00	2,081,211,060.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,598,910,100.00	1,710,512,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,598,910,100.00	1,710,512,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	359,044,721.00	370,698,560.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	359,044,721.00	370,698,560.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,383,833,209.85	3,535,588,383.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,341,743,763.63	3,535,588,383.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,093,017,889.37	3,217,841,228.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,430,701,909.00	2,177,822,876.29
210101	Үндсэн цалин	1,430,701,909.00	2,177,822,876.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,403,399.11	275,329,765.35
21020	Тэтгэврийн даатгал	181,403,399.11	275,329,765.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,981,254.00	23,234,005.10
210301	Гэрэл, цахилгаан	5,974,090.00	6,466,751.00
210302	Түлш, халаалт	11,868,050.00	9,094,550.00
210303	Цэвэр, бохир ус	3,139,114.00	7,672,704.10
2104	Хангамж, бараа материалын зардал	159,059,804.00	83,626,414.62
210401	Бичиг хэрэг	84,213,300.00	51,501,550.00
210402	Тээвэр, шатахуун	9,647,400.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,993,000.00	8,997,374.00
210404	Ном, хэвлэл	-	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	55,206,104.00	8,583,420.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	14,544,070.00
2105	Нормативт зардал	311,670,230.51	199,597,681.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	303,215,230.51	181,597,681.25
210502	Хоол, хүнс	8,455,000.00	18,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,524,938.19	3,870,000.00
210602	Тавилга	604,938.19	0
210604	Урсгал засвар	7,920,000.00	3,870,000.00
2107	Томилолт, зочны зардал	31,664,160.00	28,365,500.00
210702	Дотоод албан томилолт	31,664,160.00	28,365,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	299,838,703.00	104,417,503.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	294,451,214.00	94,071,920.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	9,384,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	367,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,489.00	289,983.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	44,000.00

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	260,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	649,173,491.56	321,577,482.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,150,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,533,000.00	173,786,340.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	598,640,491.56	144,640,242.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	248,725,874.26	317,747,155.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,231,500.00	221,827,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,731,500.00	192,924,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,500,000.00	28,903,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	211,494,374.26	81,156,834.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,494,374.26	81,156,834.30
213304	Хөрөнгийн	-	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		14,762,521.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		14,762,521.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,089,446.22	
2200	Дотоод эх үүсвэрээр	42,089,446.22	
220001	Барилга байгууламж	29,410,616.08	
222001	Тоног төхөөрөмж	12,678,830.14	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(288,839,558.85)	347,593,461.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(288,839,558.85)	347,593,461.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,925,120,718.00	3,472,570,828.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	967,165,897.00	1,395,058,328.00
120	Нийтлэг татварын бус орлого	967,165,897.00	1,395,058,328.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	967,165,897.00	1,395,058,328.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	959,132,223.00	1,391,353,253.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,033,674.00	0.00
120009	Бусад орлого		3,705,075.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,957,954,821.00	2,077,512,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,598,910,100.00	1,710,512,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,598,910,100.00	1,710,512,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	359,044,721.00	367,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	359,044,721.00	367,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,914,432,363.00	3,464,237,328.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,914,432,363.00	3,464,237,328.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,650,943,967.74	3,162,322,693.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,483,731,650.74	2,105,725,720.00
210101	Үндсэн цалин	882,949,861.16	1,055,660,512.24
210102	Нэмэгдэл	331,552,237.58	656,059,378.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,784,918.00	152,330,314.73
210104	Урамшуулал	172,444,634.00	241,675,514.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	335,929,200.00	249,488,400.00
210201	Тэтгэврийн даатгал	278,227,100.00	175,782,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,425,500.00	18,426,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,540,400.00	14,741,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,885,100.00	3,685,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,851,100.00	36,852,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,981,254.00	23,234,005.10
210301	Гэрэл, цахилгаан	5,974,090.00	6,466,751.00
210302	Түлш, халаалт	11,868,050.00	9,094,550.00
210303	Цэвэр, бохир ус	3,139,114.00	7,672,704.10
2104	Хангамж, бараа материалын зардал	81,777,500.00	86,059,674.62
210401	Бичиг хэрэг	19,797,700.00	29,774,300.00
210402	Тээвэр, шатахуун	9,631,400.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,993,000.00	8,997,374.62
210404	Ном, хэвлэл	12,660,000.00	28,920,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,695,400.00	18,368,000.00
2105	Нормативт зардал	302,393,400.00	291,928,335.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	293,938,400.00	273,928,335.00
210502	Хоол, хүнс	8,455,000.00	18,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,574,100.00	78,182,215.98
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,654,100.00	74,312,215.98
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	7,920,000.00	3,870,000.00
2107	Томилолт, зочны зардал	31,664,160.00	28,365,500.00
210702	Дотоод албан томилолт	31,664,160.00	28,365,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	323,386,103.00	124,818,043.00

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	310,384,614.00	97,292,460.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	9,384,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	367,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,489.00	289,983.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		44,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,614,000.00	17,440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,506,600.00	174,520,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,506,600.00	174,520,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	263,488,395.26	301,914,634.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,231,500.00	221,827,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,731,500.00	192,924,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,500,000.00	28,903,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	226,256,895.26	80,086,834.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,494,374.26	80,086,834.30
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт	14,762,521.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,688,355.00	8,333,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,688,355.00	8,333,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,688,355.00	8,333,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,688,355.00	8,333,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,688,355.00)	(8,333,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ 8=3+6+7	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	690,350,380.90	-	1,785,294,733.69	2,475,645,114.59
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	690,350,380.90	-	1,785,294,733.69	2,475,645,114.59
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(288,839,558.85)	(288,839,558.85)
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	690,350,380.90	-	1,496,455,174.84	2,186,805,555.74
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	270,287,634.60	270,287,634.60
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	690,350,380.90	-	1,766,742,809.44	1,766,742,809.44
16	Тайлант үеийн үр дүн	-	-	347,593,461.01	347,593,461.00
17	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	690,350,380.90	-	2,114,336,270.45	2,804,686,651.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,143,301,400.00	2,857,147,112.70	286,154,287.30	90.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,143,301,400.00	2,857,174,112.70	286,154,287.30	90.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,921,261,300.00	2,656,719,312.70	264,541,987.30	90.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,995,911,200.00	1,995,911,200.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	1,107,382,000.00	1,047,168,433.08	60,213,566.92	94.6
210102	Нэмэгдэл	573,836,000.00	579,513,839.16	(5,677,839.16)	101.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	124,416,000.00	152,330,314.73	(27,914,314.73)	122.4
210104	Урамшуулал	190,277,200.00	216,898,613.03	(26,621,413.03)	114.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,488,400.00	249,488,400.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	175,782,800.00	175,782,800.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	18,426,300.00	18,426,300.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,741,200.00	14,741,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,685,200.00	3,685,200.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	36,852,900.00	36,852,900.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,360,900.00	23,234,005.10	6,126,894.90	79.1
210301	Гэрэл, цахилгаан	11,015,200.00	6,466,751.00	4,548,449.00	58.7
210302	Түлш, халаалт	9,601,800.00	9,094,550.00	507,250.00	94.7
210303	Цэвэр, бохир ус	8,743,900.00	7,672,704.10	1,071,195.90	87.7
2104	Хангамж, бараа материалын зардал	58,658,300.00	32,512,674.62	26,145,625.38	55.4
210401	Бичиг хэрэг	29,529,300.00	9,347,300.00	20,182,000.00	31.7
210402	Тээвэр, шатахуун	300.00	0.00	300.00	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,755,300.00	8,997,374.62	1,757,925.38	83.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,373,400.00	14,168,000.00	4,205,400.00	77.1
2105	Нормативт зардал	292,049,000.00	273,928,335.00	18,120,665.00	93.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	274,049,000.00	273,928,335.00	120,665.00	100.0
210502	Хоол хүнс	18,000,000.00	0.00	18,000,000.00	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,661,600.00	9,500,854.98	160,745.02	98.34
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,780,000.00	5,630,854.98	149,145.02	97.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00	0.00	0.0
210604	Урсгал засвар	3,881,600.00	3,870,000.00	11,600.00	99.7
2107	Томилолт, зочны зардал	17,903,700.00	17,899,500.00	4,200.00	100.0
210702	Дотоод албан томилолт	17,903,700.00	17,899,500.00	4,200.00	100.0

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,831,900.00	52,651,543.00	44,180,357.00	54.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,412,400.00	21,303,460.00	44,108,940.00	32.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,384,000.00	9,384,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	367,600.00	367,600.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,300.00	289,983.00	25,317.00	92.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	64,700.00	44,000.00	20,700.00	68.0
210807	Газрын төлбөр	3,822,500.00	3,822,500.00	0.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,465,400.00	17,440,000.00	25,400.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	171,396,300.00	1,592,800.00	169,803,500.00	0.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	171,396,300.00	1,592,800.00	169,803,500.00	0.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	222,040,100.00	200,427,800.00	(40,628,655.30)	118.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	222,040,100.00	200,427,800.00	21,612,300.00	90.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	192,924,800.00	192,924,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,115,300.00	7,503,000.00	21,612,300.00	25.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,865,691,400.00	2,857,147,112.70	(53,696,668.00)	0.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,710,724,800.00	1,648,271,544.70	62,453,255.30	96.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,710,724,800.00	1,648,271,544.70	62,453,255.30	96.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,154,966,600.00	1,208,875,568.00	(53,908,968.00)	104.6
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,154,966,600.00	1,208,159,053.00	(53,192,453.00)	104.6
120009	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	716,515.00	(716,515.00)	0.0
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	96	96	-	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	59	59	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	35	35	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		553,182,760.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		553,182,760.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		513,936,881.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал		109,814,520.00
210101	Үндсэн цалин		8,492,079.16
210102	Нэмэгдэл		76,545,539.75
210104	Урамшуулал		24,776,901.09
2104	Хангамж, бараа материалын зардал		53,547,000.00
210401	Бичиг хэрэг		20,427,000.00
210404	Ном, хэвлэл		28,920,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,200,000.00
2105	Нормативт зардал		18,000,000.00
210502	Хоол, хүнс		18,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		73,192,361.00
210601	Багаж техник, хэрэгсэл		73,192,361.00
2107	Томилолт, зочны зардал		10,466,000.00
210702	Дотоод албан томилолт		10,466,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		75,989,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		75,989,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		172,928,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		172,928,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		39,245,879.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		21,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		21,400,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		17,845,879.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		17,845,879.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		553,182,760.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		186,182,760.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		183,194,200.00
1200045	туслах үйл ажиллагааны орлогоос		2,628,560.00
120009	Бусад орлого		360,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		367,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		367,000,000.00

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,419.3 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
1	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны үзүүлэлт нягтлан бодох бүртгэлийн программ дах мэдээллээс зөрүүтэй байна.	1	3,094,993.6			1	3,094,993.6	1	3,094,993.6				
2	Санхүүгийн байдлын тайлангийн өмнөх оны үр дүнг 241,800.5 мянган төгрөгөөр үндэслэлгүй нэмэгдүүлсэн.	1	241,800.5			1	241,800.5	1	241,800.5				
3	Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны үр дүнг 82,509.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	82,509.4			1	82,509.4	1	82,509.4				
	Дүн	3	3,419,303.5			3	3,419,303.5	3	3,419,303.5				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитаар нийт 513.0 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 168.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 344.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
1	Тус төв нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.	1	-			1	-								
2	Тайлант онд 193,640.4 мянган төгрөгийн авлага, 150,779.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	344,419.7					1	344,419.7						
3	Үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 768 нэр төрлийн	1	-					1	-						

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	1,349,362.1 мянган төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө байна. Хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж хөрөнгийг үнэгүйдэх эрсдэлээс сэргийлж ажиллаагүй байна.											
4	Тайлант хугацаанд эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах тендерт ирүүлсэн оролцогчдын материалыг чанар ба үнэлгээний аргаар үнэлээгүй. Багц 2 -т шалгарсан Мисс ди ХХК (гэрээний үнийн дүн 168,623.2 мянган төгрөг) тендерийн гүйцэтгэлийн баталгаа аваагүй, тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг тусгаагүй байна.	1	168,623.2			1	168,623.2					
Дүн		4	513,042.9			2	168,623.2	2	344,419.7	1	-	

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 853.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 853.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах тендерийн Багц 2-т шалгарсан оролцогч нь гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй нь тендерийн баталгааг улсын орлого болох үндэслэл болсон бөгөөд тендерийн баталгааг улсын орлого болгоогүй.	1	853.3	1	853.3								
2	Шилэн дансны цахим нэгдсэн системд нийт 10 удаагийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-			1	-						
3	Санхүүгийн баримтуудыг үдэж архивласан ч баримтуудыг огнооны дарааллаар үдээгүй, цахим архив үүсгээгүй байна.	1	-			1	-						
	Дүн	3	853.3	1	853.3	2	-					-	